

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /10-р сарын 23-нөөс 11-р сарын 20-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	X/23	X/30	XI/06	XI/13	XI/20
1	Гурил, I зэрэг, кг	700	700	700	700	700
2	Хонины мах, кг/ ястай/	6500	6500	6000	6000	6000
3	Үхрийн мах, кг /ястай/	7500	7500	7500	7500	7500
4	Ямааны мах /ястай /	5500	5500	5500	5500	5250
5	Элсэн чихэр, кг	1550	1550	1550	1550	1550
6	Цагаан будаа, кг	2100	2100	2100	2100	2100
7	Шингэн сүү, л	1000	1200	1200	1250	1300
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан					
9	- Бор ноолуур					
10	Бензин, А-80, 1 литр	1550	1550	1550	1550	1550
11	Бензин, А-92, 1 литр	1650	1650	1650	1650	1650
12	Дизелийн түлш, 1 литр	1750	1750	1750	1750	1750

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2013 оны 10-р сарын 23-наас 11-р сарын 20-ны хооронд хонь ямааны ястай махны үнэ буурч, шингэн сүүний үнэ өсч өөрчлөгдөв. Бусад бүтээгдэхүүний үнэ тогтвортой байв. Энэ хугацаанд ноолуурын арилжаа хийгдсэнгүй.

Махны үнэ. Үхрийн ястай мах сүүлийн 5 долоо хоногийн туршид өөрчлөгдөөгүй байна. 1 кг хонины ястай мах 10-р сарын 30-ныг хүртэл 6500 төгрөг байсан ба 11-р сарын 6-наас хойш 7,7 хувиар буурч 6000 төгрөгийн ханштай байна. Ямааны ястай мах 11-р сарын 13-ныг хүртэл 5500 төгрөг байсан бол 11-р сарын 20-нд 5250 төгрөг болж өмнөх 7 хоногийн ханшаас 4,4%-аар буурав.

Гурил, элсэн чихэр, цагаан будаа. Сүүлийн 5 долоо хоногийн туршид гурил, элсэн чихэр, цагаан будааны дундаж үнэ тогтвортой байж өөрчлөгдсөнгүй.

Шингэн сүү. Хүйтний улирал ирж буйтай холбоотойгоор шингэн сүүний нийлүүлэлт багасч үнэ нь өсч байна. 10-р сарын 23-нд 1000 төгрөг байсан сүү 10-р сарын 30, 11-р сарын 06-нд 1200, 11-р сарын 13-нд 1250, 11-р сарын 20-нд 1300 төгрөг болж харгалзан өмнөх 7 хоногоос 20%, 4,2%, 3,8%-аар тус тус өсөв.



